

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/85/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
1. Аудитын гэрчилгээ	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Албан шаардлага	18
4.3 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/189
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 19020586

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,226,199.01	74,800,220.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	174.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	174.00	-
33	АВЛАГА	76,801.01	92,110.01
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	76,801.01	76,801.01
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	15,309.00
35	БАРАА МАТЕРИАЛ	73,149,224.00	74,708,110.00
351	Түүхий эд материал	134,145.00	-
35130	Эм боох материал	134,145.00	-
354	Хангамжийн материал	73,015,079.00	74,708,110.00
35410	Бичиг хэргийн материал	541,970.00	623,000.00
35420	Аж ахуйн материал	6,146,629.00	4,951,629.00
35450	Барилгын засварын материал	3,154,000.00	2,049,000.00
35470	Бусад хангамжийн материал	63,172,480.00	67,084,481.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,862,912,616.33	1,860,523,002.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,862,912,616.33	1,860,523,002.42
392	Биет хөрөнгө	1,436,413,283.21	1,434,066,169.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,252,377,742.00	1,213,265,142.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(72,166,259.22)	(96,347,654.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,094,800.00	169,594,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(78,738,765.61)	(90,233,319.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,403,015.44	88,934,010.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(127,363,262.97)	(30,485,809.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,408,899.25	75,295,434.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,187,838.33)	(27,174,195.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	307,336,525.00	328,115,086.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(186,751,572.35)	(196,897,323.45)
393	Биет бус хөрөнгө	426,499,333.12	426,456,833.08
39301	Програм хангамж	340,000.00	340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(226,666.88)	(269,166.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	426,386,000.00	426,386,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,936,138,815.34	1,935,323,222.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,936,138,815.34	1,935,323,222.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,936,138,815.34	1,935,323,222.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	710,837,936.62	710,837,936.62
51101	Өмч: - төрийн	710,837,936.62	710,837,936.62
51220	Тайлант үеийн үр дүн	(14,079,870.99)	(815,584.00)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	374,463,987.42	315,160,096.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,936,138,815.34	1,935,323,222.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	518,390,058.90	660,704,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,801,423.00	112,361,826.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,801,423.00	112,361,826.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,801,423.00	112,361,826.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,801,423.00	112,361,826.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	477,588,635.90	548,342,804.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,093,935.90	80,508,404.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	31,809,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,500,000.00	10,151,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,162,185.90	23,556,604.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,431,750.00	14,991,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,494,700.00	467,834,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,494,700.00	467,834,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	532,469,929.89	634,576,200.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,369,929.89	634,576,200.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,070,272.31	560,496,578.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,546,466.42	235,209,735.86
210101	Үндсэн цалин	200,694,951.42	185,619,003.02
210102	Нэмэгдэл	606,084.00	16,410,611.57
210105	Гэрээт ажлын хөлс	32,245,431.00	33,180,121.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,875,501.00	30,003,209.00
210201	Тэтгэврийн даатгал	19,913,013.00	21,164,551.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,342,706.00	2,368,777.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,857,365.00	1,888,302.49
210204	Ажилгүйдлийн даатгал	432,949.00	416,507.53
210205	Эрүүл мэндийн даатгал	4,329,468.00	4,165,069.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,012,075.02	75,094,496.96
210301	Гэрэл, цахилгаан	6,671,742.82	5,370,072.96
210302	Түлш, халаалт	57,313,132.20	62,559,024.00
210303	Цэвэр, бохир ус	27,200.00	7,165,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,724,221.00	45,340,368.63
210401	Бичиг хэрэг	4,325,730.00	4,476,544.00
210402	Тээвэр, шатахуун	20,087,761.00	29,455,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	926,250.00	930,329.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	833,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,544,480.00	2,683,150.00
210408	Бараа материал акталсны зардал	11,840,000.00	6,961,215.00
2105	Нормативт зардал	2,930,570.00	3,660,650.00
210502	Хоол, хүнс	2,388,520.00	3,263,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	542,050.00	397,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,230,000.00	3,462,000.00
210604	Урсгал засвар	3,230,000.00	3,462,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,699,100.00	2,701,400.00
210702	Дотоод албан томилолт	2,699,100.00	2,701,400.00

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,620,066.00	1,864,841.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,108,566.00	353,341.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	756,700.00	756,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,432,272.87	163,159,877.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,823,565.00	81,692,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,608,707.87	81,467,417.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,299,657.58	74,079,621.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,000.00	48,734,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,734,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,239,657.58	25,345,221.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,239,657.58	25,345,221.55
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,100,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,100,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	5,100,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,079,870.99)	26,128,429.80
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	4,682,500.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	4,682,500.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	31,626,513.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	31,626,513.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(26,944,013.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,079,870.99)	(815,584.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	562,518,804.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	562,518,804.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	94,684,404.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	31,809,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,151,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	23,556,604.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	29,167,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	467,834,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	467,834,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	561,990,978.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	561,990,978.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	486,911,356.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	236,513,408.90
210101	Үндсэн цалин	-	186,007,349.04
210102	Нэмэгдэл	-	15,675,302.82
210105	Гэрээт ажлын хөлс	-	34,830,757.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	28,699,535.96
210201	Тэтгэврийн даатгал	-	19,860,879.40
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,368,776.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,888,301.57
210204	Ажилгүйдлийн даатгал	-	416,507.07
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,165,071.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	75,094,496.96
210301	Гэрэл, цахилгаан	-	5,370,072.96
210302	Түлш, халаалт	-	62,559,024.00
210303	Цэвэр, бохир ус	-	7,165,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	41,533,999.63
210401	Бичиг хэрэг	-	4,088,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	28,648,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	930,329.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,866,800.00
2105	Нормативт зардал	-	3,699,000.00
210502	Хоол, хүнс	-	2,899,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,486,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,000.00
210604	Урсгал засвар	-	4,484,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,701,400.00
210702	Дотоод албан томиллолт	-	2,701,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,143,841.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	632,341.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	756,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	150,000.00

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	92,039,674.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	91,883,674.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	156,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	75,079,621.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	49,734,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	48,734,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	25,345,221.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,345,221.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	527,826.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	528,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	528,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	528,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	528,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(528,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(174.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	174.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	174.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	864,916,762.29	1,950,218,686.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	864,916,762.29	1,950,218,686.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,079,870.99	-14,079,870.99
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	850,836,891.30	1,936,138,815.34
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	850,836,891.30	1,936,138,815.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	850,836,891.30	1,936,138,815.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	59,303,882.26	59,303,882.26
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	710,837,936.62	374,463,987.42	910,140,773.56	1,995,442,697.60
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	-59,303,891.17	00.00	-59,303,891.17
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,421,675,873.24	689,624,083.67	1,820,281,547.12	3,931,581,504.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,720,900.00	444,135,918.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,720,900.00	444,135,918.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,986,500.00	395,401,518.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,142,900.00	236,513,408.90
210101	Үндсэн цалин	166,673,400.00	186,007,349.04
210102	Нэмэгдэл	47,184,000.00	15,675,302.82
210105	Гэрээт ажлын хөлс	39,285,500.00	34,830,757.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,565,400.00	28,699,535.96
210201	Тэтгэврийн даатгал	24,457,200.00	19,860,879.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,527,000.00	2,368,776.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,021,600.00	1,888,301.57
210204	Ажилгүйдлийн даатгал	505,400.00	416,507.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,054,200.00	4,165,071.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,536,400.00	66,536,400.00
210301	Гэрэл, цахилгаан	6,673,000.00	5,370,072.96
210302	Түлш, халаалт	59,637,400.00	60,940,327.04
210303	Цэвэр, бохир ус	226,000.00	226,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,909,500.00	18,909,499.63
210401	Бичиг хэрэг	3,302,500.00	3,407,400.00
210402	Тээвэр, шатахуун	12,577,000.00	12,571,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	930,329.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,563,800.00	2,474,000.00
210702	Дотоод албан томилолт	4,563,800.00	2,474,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,511,500.00	1,511,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	756,700.00	756,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,457,000.00	38,457,174.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,457,000.00	38,457,174.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,734,400.00	48,734,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,734,400.00	48,734,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,734,400.00	48,734,400.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	468,720,900.00	444,135,744.49
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	468,720,900.00	444,135,744.49
122005	Орон нутгийн төсвөөс	468,720,900.00	444,135,744.49
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(174.00)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	93,037,837.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,093,761.00	93,037,837.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,093,761.00	92,037,837.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	8,558,096.96
210302	Түлш, халаалт	-	1,618,696.96
210303	Цэвэр, божир ус	-	6,939,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,500,000.00	22,624,500.00
210401	Бичиг хэрэг	-	681,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	16,076,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	5,866,800.00
2105	Нормативт зардал	-	2,899,000.00
210502	Хоол, хүнс	-	2,899,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,699,400.00	3,514,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	530,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	2,984,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	227,400.00
210702	Дотоод албан томилолт	-	227,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,551,382.00	632,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйл	9,551,382.00	632,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,342,979.00	53,582,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,342,979.00	53,426,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	156,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	801,400.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох та	-	801,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,093,935.00	93,839,237.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,093,935.00	93,839,237.96
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээ	-	31,809,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагда	12,500,000.00	9,318,633.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгаг	25,162,185.00	23,556,604.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаан	5,431,750.00	29,155,000.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Цээл сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинээр боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ЗДТГ-ын даргын 2017 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн № А/03 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг хариуцсан албан тушаалтнаар төрийн сангийн мэргэжилтнээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, хяналт хийх тухай бүрд нь удирдамжаар томилдог байна. ЗДТГ-ын даргын тушаалаар 2021 оны дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө хуваарийг баталсан.

Дотоод хяналт шалгалтын удирдамжид заасны дагуу санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, анхан шатны бүрдүүлэлт, өмчийн бүртгэл тооцоо ашиглалт хадгалалтад хяналт тавих, нярав складын бүртгэлийн эмч цэгц, байгууллагад шинээр авсан эд хөрөнгө болон хандив тусламжийн хөрөнгүүдийг бүртгэлд авсан эсэхэд хяналт тавих, шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэл суулгасан явцад хяналт тавихаар тусгасан байна.

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ-ын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 660,704.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,910.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,432.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 660,704.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,910.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,432.9 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас өөрчлөгдөөгүй байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 467,834.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 467,834.4 мянган төгрөг буюу 100% авсан байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд ААНБ, иргэдээс 28,809.0 мянган төгрөгийн хандив тусламж, архивын лавлагааны хураамж 711.0 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 28,456.0 мянган төгрөг, Засгийн газраас төлсөн усны үнэ 7,740.8 мянган төгрөг, халаалтын өр шийдвэрлэхэд 36,464.1 мянган төгрөг, аймгийн ОБГ-аас шүлхийтэй тэмцэх санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ-өөс 39,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 561,990.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд Би-Гарм ХХК-ий хийсэн 20,778.0 мянган төгрөгийн 2 худаг, 18,000.0 мянган төгрөгийн Hyundai Mighty-2 автомашин, дахин үнэлгээгээ болон шилжүүлгээр 71,397.8 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч, Аймгийн ИТХ-Н 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн №27 тоот тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 82,861.9 мянган төгрөгийн ЗДТГ-н хуучин барилга, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг акталсан байна.

Бараа материалын дансанд ОБГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,075.0 мянган төгрөгийн хүнс дархлаажуулалтын багц, иргэдээс 505.0 мянган төгрөгийн хамгаалах хэрэгсэл, сонгуулийн хорооны 605.0 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн байна. Нийт 112,572.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 111,013.4 мянган төгрөгийн бараа материал зарлагдсан байна.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар урьд оны цалингийн авлагын үлдэгдэл 76.8 мянган төгрөг, тайлант онд 15.3 мянган төгрөгийн авлага нэмэгдэж 92.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.17	-	(0.17)
Авлага	76.80	92.11	15.31
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	73,149.22	74,708.11	1,558.89
Үндсэн хөрөнгө	1,862,912.62	1,860,523.00	(2,389.61)
Нийт хөрөнгө	1,936,138.82	1,935,323.22	(815.59)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	1,936,138.82	1,935,323.22	(815.59)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,936,138.82	1,935,323.22	(815.59)

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцах дансны үлдэгдэл 0 төгрөг, Авлага данс 92.1 мянган төгрөг, бараа материал 70,192.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1874852,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл нь 15.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 92.1 мянган төгрөг болсон байна. Бараа материалын дансны үлдэгдэл 74,708.1 мянган төгрөг болж 1,558.89 мянган төгрөг болж нэмэгдсэн нь бусад хангамжийн материал 3,912.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүн 1,860,523.0 мянган төгрөг болж 2,389.6 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн №27 тоот тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 82,861.9 мянган төгрөгийн ЗДТГ-н хуучин барилга, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлыг акталсан, тайлант оны хуримтлагдсан элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,935,323.2 мянган төгрөг болж 815.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 467,834.4 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 467,834.4 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 467,834.4 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанд 395,401.4 мянган төгрөг, тэтгэмж урамшуулалд 48,734.3 мянган төгрөг зарцуулж, 23,698.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ААНБ, иргэдээс 28,809.0 мянган төгрөгийн хандив тусламж, архивын лавлагааны хураамж 711.0 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 28,456.0 мянган төгрөг, Засгийн газраас төлсөн усны үнэ 7,740.8 мянган төгрөг, халаалтын өр шийдвэрлэхэд 36,464.1 мянган төгрөг, аймгийн ОБГ-аас шүлхийтэй тэмцэх санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ-өөс 39,000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цээл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд онцлох асуудал 76.8 мянган төгрөгийн цалингийн авлагыг барагдуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Харилцагч байгууллагатай хийсэн 33,506.3 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын Е баримт болон Е постоор баталгаажуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн №67 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цээл сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал цалингийн авлага барагдуулалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43,091.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,493.5 мянган төгрөгийн алдааг залруулж, татварын цахим төлбөрийн баримттай холбоотой 33,506.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилт, авлага барагдуулалттай холбоотой 92.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

4.1.1 Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 9,493.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

4.2.1 Харилцагч байгууллагатай хийсэн 33,506.3 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” бол албан шаардлага өгөх гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Авлага данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Ажиллагсдаас авах авлага 76.8 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 15.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Он дамжсан 92.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж цаашид авлага, өр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 13 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан төлөвтэй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс					
				Залруулга		Зөвлөмж		Албан шаардлага	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Цээл сумын ЗДТГ	7	43,091.9	4	9,493.5	2	92.1	1	33,506.3